

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН БУЯНТ-УХАА ДАХЬ ГАЗРААС  
2018 ОНЫ АРВАН ХОЁРДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 11

Буянт-Ухаа

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Засгийн газрын 2018 оны 145, 146 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам” болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудыг удирдлага болгон иргэнд хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2018 оны 11 дүгээр сарын 26-наас 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1. Монгол Улсын виз, бүртгэлийн талаар:

Тайлант хугацаанд нийт 53 орны 176 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон бөгөөд үүнээс визийн шилжүүлэг 4 байна. Үүнд, нэг удаагийн орох 144, хоёр удаагийн орох 2, олон удаагийн орох 7, нэг удаагийн гарах-орох 14, хоёр удаагийн гарах-орох 1, олон удаагийн гарах-орох 4, дамжин өнгөрөх 0, түр ирэгчийн бүртгэл 22, хасалт 26, оршин суух зөвшөөрлийн хасалт 55 байна.

Визийн хуудас 2 ширхэгийг тус газрын албан хаагч хүчингүй болгож, шинээр виз олгосон ба оршин суух зөвшөөрөлд хасалт хийгдээд олон удаагийн виз хүчингүй болгосон нийт 2 орны 2 иргэнд оршин суух зөвшөөрөл олгохдоо олон удаагийн визийг хэвээр үлдээсэн байсныг хүчингүй болгосон.

1.2. Гадаадын иргэдэд тавих хяналт шалгалтын хүрээнд:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталсан УБ-02/2018-010 тоот удирдамжийн дагуу мөн оны 12 дугаар сарын 05-ны өдөр Төв аймгийн Зуунмод сумын 1-р багт амьдардаг 1 орны 1 гадаадын иргэний амьдралын түвшинг тогтоохоор хяналт шалгалт хийж улсын байцаагчийн дүгнэлт бичин төвд хүргүүлсэн.

Тайлант хугацаанд Төв аймгийн 16 суманд оршин суугаа тус газарт бүртгэлтэй 15 орны 280 гадаадын иргэн /харьяалалгүй 1/, гадаадын хөрөнгө оруулалттай 12 аж ахуйн нэгж байгаа бөгөөд мэдээг Төв аймгийн Цагдаагийн газартай хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу тус байгууллагад 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хүргүүлсэн. Төв аймгийн хэмжээнд гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэн бүртгэгдээгүй байна.

Мөн Төв аймгийн Засаг дарга 2018 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгуулсан хамтран ажиллах гэрээний тус газартай холбоотой арга хэмжээний биелэлтийг гаргаж аймгийн Хууль зүйн хэлтэст өгч, 2019 онд байгуулах хамтран ажиллах гэрээнд тус газраас тусгах саналыг 3 төрөл заалтаар гарган аймгийн Хууль зүйн хэлтэст хүргүүлэн ажилласан.

Үүнээс гадна “ISM” системээр 45 орны 8178 гадаадын иргэний мэдээллийг шүүж шалгасан бөгөөд орон нутгийн нислэгээр зорчсон нийт 14 орны 29 гадаадын иргэний бичиг баримтад шалгалт хийхэд зөрчил илрээгүй болно.

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага /IOM/-аас өгсөн бичиг баримтын хуурмаглал шалгах төхөөрөмжийг ашиглан нийт 5 орны 21 гадаадын иргэний бичиг баримт, мэдээллийг шалгав.

1.3. Захиргааны арга хэмжээ авсан талаар:

Тайлангийн хугацаанд бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн, визийн хугацаа хэтрүүлсэн, оршин суух журам зөрчсөн зэрэг үндэслэлээр 7 гадаадын иргэнд 830,000 төгрөг, 1 аж ахуйн нэгжид /хамрагдсан гадаадын иргэн 1/ 80,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгөв.

1.4. Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний талаар:

Тайлант хугацаанд ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан 1 орны 1 гадаадын иргэнийг тус улсаас албадан гаргасан болно.

Түүнчлэн төвөөс нийт 3 орны 3 гадаадын иргэнийг албадан гаргаж буй үйл ажиллагаанд тус газрын албан хаагчид оролцож, тодорхойлолт үйлдэв.

1.5. Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн талаар:

Тайлант хугацаанд ирсэн зорилгоо тодорхойлж чадаагүй 2 орны 2 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан ба гарах визгүй, аж ахуйн нэгжийн албан бичиггүй зэрэг үндэслэлээр 3 орны 4 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр гаргаагүй болно.

Харин шүүх, прокурор, ШШГЕГ-ын хүсэлтийн дагуу Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн байхгүй байна.

1.6. Ярилцлагын тэмдэглэл болон баталгаа гаргуулан хил нэвтрүүлсэн талаар:

Монгол улсад визгүй зорчигч гадаадын иргэн, хөдөлмөр эрхлэх магадлалтай 3 орны 13 гадаадын иргэнтэй ярилцлага хийж бичиг баримтыг хуулбарлан хилээр гарсан байдалд хяналт тавьж бүртгэл хөтөлсөн болно.

Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсад зорчин ирж буй 1 орны 2 гадаадын иргэнийг угтан авч буй Монгол Улсын иргэнээр баталгааны анкет бөглүүлэн хил нэвтрүүлж, уг гадаадын иргэний гарах хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна.

1.7. Иргэний харьяаллын талаар:

Хоёрдмол харьяалал үүсгэсэн 2 орны 4 иргэнээр өргөдөл-анкетыг бөглүүлэн холбогдох баримт бичгийг хуулбарлан авч Харьяатын газарт хүргүүлсэн.

Хоёр. Дотоод ажлын хүрээнд

2.1. Тушаал, төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар:

Тайлант хугацаанд тус газрын даргаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой 2 /Сургалт зохион байгуулах тухай 1, Эд хөрөнгийн тооллого зохион байгуулах тухай 1/, хүний нөөцтэй холбоотой 0, нийт 2 тушаал батлан гаргасан байна. Тус газар 2018 оны арван хоёрдугаар сард хийх ажлын төлөвлөгөөнд нийт 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд 100 хувийн биелэлттэй гарлаа.

Төвөөс өгсөн үүргийн дагуу дор дурдсан судалгаа, мэдээг гаргаж тогтоосон хугацаанд хүргүүлэв. Үүнд:

- Тус газрын үндсэн үйл ажиллагааны талаарх хоногийн мэдээг гаргаж өдөр бүр, байгууллагын даргын ХЗДХСайдтай 2018 онд байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсан тус газартай холбоотой арга хэмжээний биелэлт, байгууллагын даргатай тус газрын даргын энэ онд байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, инфографик мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулан гаргаж 10-ны өдөр Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн;
- Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэвийн нэмэгдлийг шинэчлэн олгох албан хаагчийн талаарх судалгааг гаргаж 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Тамгын газарт хүргүүлсэн;
- Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон тус газраас сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах талаар 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт, Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөрийн биелэлт, “Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөн-2018”-өөс гарсан зөвлөмжийн дагуу тус газраас хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Цагдаагийн байгууллага, гадаадын иргэн, харьяатын байгууллагын хамтран ажиллах журмын биелэлт, Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтсээс ирүүлсэн 01 дүгээр зөвлөмжийн тус газартай холбоотой заалтын хэрэгжилт, Гадаадын иргэн, харьяатын газрын Буянт-Ухаа дахь газрын хяналт шалгалтын 2018 оны төлөвлөгөөний биелэлт, Тус газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт, Тус газрын сургалтын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж хүргүүлэхээр ажиллаж байна.

## 2.2. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол, архивын талаар:

Бичиг хэрэгт 1 албан бичиг ирсэнийг бүртгэлжүүлэн холбогдох албан хаагчид хүлээлгэн өгч, хариутай 1 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан ба 6 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.

Энэ сард иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчаас ирүүлсэн өргөдөл, гомдол байхгүй болно.

Тус газрын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд тус газарт ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын батлан гаргасан тушаал, тус газрын энэ сарын төлөвлөгөө, түүний биелэлт, тайланг сканердаж цахим хэлбэрт шилжүүлсэн ба тус газрын архивын өрөөний чийг, дулааныг өдөр бүр хэмжин дэвтэрт бичилт хийн ажиллаж байна. Хэмжилтээр дулаан 18-21 С, чийг 19-21 HR байна.

## 2.3. Хүний нөөц, сургалтын талаар:

Байгууллагын даргын 2017 оны Б/51-р тушаалаар тус газрын батлагдсан орон тоо 29 бөгөөд одоо ажиллаж буй 24, байгууллагын даргын тушаалын дагуу чөлөөтэй байгаа 2, декреттэй 1, хүүхэд асрах чөлөөтэй 2, баталсан хуваарийн дагуу албан хаагчид ээлжийн амралтаа эдэлж дууссан байна.

Тайлант хугацаанд Ёс зүйн хариуцлагын талонд арга хэмжээ авахуулсан албан хаагч байхгүй болно.

Албан хаагчдын 2018 онд тус газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ, төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрийн гэрээний биелэлтийг гаргуулан авч дүгнэж байна.

Төрийн албаны зөвлөлийн цахим санд тус газрын 28 албан хаагчдын мэдээллийг шивж оруулан баяжилт хийлээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/204 дүгээр тушаалын дагуу “Хүндэт жуух бичиг”-ээр тус газрын 3 албан хаагч шагнагдсан байна.

Тайлант хугацаанд төв болон тус газраас зохион байгуулсан дараах сургалтуудад албан хаагчдыг хамруулав. Үүнд:

- Төвөөс 2018.11.26-30-ны өдрүүдэд Хууль сахиулахын их сургууль дээр зохион байгуулсан бичиг баримтын хуурмаглалыг илрүүлэх арга зүйн сургалтад тус газрын 1 албан хаагч хамрагдав;
- Төвөөс 2018.12.03-аас 04-ний өдрүүдэд зохион байгуулсан захиргааны албан хаагчдын цугларалтад тус газрын 1 албан хаагч хамрагдаж албаны үйл ажиллагаа, тулгамдаж байгаа асуудлын талаар хэлэлцэв;
- Тус газраас 2018.12.05-ны өдөр хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх сургалт зохион байгуулж тус газрын 14 албан хаагч хамрагдан мэдлэгээ дээшлүүлэв. Сургалтад Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтсийн хэлтсийн эдийн засгийн ахлах мөрдөгч Б.Батжаргал, эрүүгийн мөрдөгч Н.Батцэнгэл нар хичээл оров.
- Тус газраас 2018.12.05-ны өдөр мэдээллийн аюулгүй байдлын эсрэг хийж байгаа гэмт халдлагын төрөл, хийгдэх болсон шалтгаан, түүнээс урьдчилан сэргийлэх аргын талаар сургалт зохион байгуулж Мэдээллийг технологийн хэлтсийн сүлжээний ерөнхий инженер ирж 14 албан хаагчдад мэдээлэл хийв.

#### 2.4. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар:

Тайлант хугацаанд батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан ба холбогдох мэдээллийг шилэн дансанд байршуулсан.

Батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан. Батлагдсан төсөв болох өссөн дүнгээр 548,495,500 төгрөгийн санхүүжилт орсноор цалин хөлсөнд 302,349,745 төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл 41,023,423 төгрөг, ХУД-т цалин хөлснөөс суутгасан ашгийн татварт 26,359,392 төгрөг, хангамж, бараа материалын зардалд 43,017,238 төгрөг зарцуулж өглөг авлага үүсгээгүй ажиллалаа.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2018.12.02-ны дотор гарган ХУД-ийн төрийн сангаар баталгаажуулан Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн. Мэдээгээр 510,405,100 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 451,716,296 төгрөгийн ажил үйлчилгээ явуулсан.

Нийгмийн даатгалын шитгэлийн тайланг гарган 2018.12.05-ны дотор Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэн 75,944,146 төгрөгөөр тооцоо нийлэв.

Албан хаагчдад шийтгэлийн хуудас 49, визийн хуудас 300 ширхэгийг шаардах хуудасны дагуу олгосон. Түүнчлэн авто машины ашиглалт болон шатах тослох материалын тооцоог жолооч дэвтэрт бичилтийг хийн бүртгэл хөтлөв.

Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт 3,509,496 төгрөг, байрны түрээс 26,632,250 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс руу шилжүүлсэн болно.

Хүү торгууль өссөн дүнгээр 93,010,000 төгрөгийг Төв аймгийн төрийн санд, визийн тэмдэгтийн хураамж өссөн дүнгээр 433,420,510 төгрөг, визийн хуудас өссөн дүнгээр 32,701,708 төгрөгөөр тайлан нэгтгэн хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.

Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан.

Түлш шатах тослох материалд өссөн дүнгээр 30,980,100 төгрөгний зарцуулалт гаргаж тайлагнасан байна.

Тус газрын 26 албан хаагч, хүүхэд асрах чөлөөтэй 1 албан хаагчийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулав.

Үйлчилгээнд явж буй автомашины цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж, батлагдсан маршрутын дагуу албан хаагчдыг тээвэрлэж, замын хуудсыг бөглөн санхүүтэй тооцоо нийлж ажиллав.

Түүнчлэн 93-84 УБН улсын дугаартай Приус-20 маркийн автомашинд урд салхины шил, жолооны хүрдний аппарат, хойд талын 4 наклад, 2 талын цапны шарик, моторын тос, форсункийг тус тус худалдан авч солив. Түүнчлэн 04-34 УБҮ улсын дугаартай Соната-7 маркийн автомашинд таван бул 2, яндан турба1, саран деод 1, свеча 4, катушка 4, хагас гол 1 ширхэгийг тус тус худалдан авч сольсон.

Тус газар нь Төв аймаг дахь ахлах мэргэжилтэний үйл ажиллагаагаа явуулдаг албан тасалгаа болон захиргаа байрладаг байр, “Чингис хаан” олон улсын нисэх буудалд албан хаагчдын үйл ажиллагаа явуулдаг болон амралтын өрөөнд тус тус засварын ажлыг хийлээ. Засвар үйлчилгээнд нийт 1,650,000 төгрөг зарцуулсан.

#### 2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Тайлант хугацаанд дотоод сүлжээний 5, техник хэрэгслийн 3, нийт 8 дуудлага хүлээн авч засварлан хэвийн ажиллагаанд оруулсан. Үүнд:

- “Чингис Хаан” олон улсын нисэх буудлын тус газрын харьяа явагчийн өрөөний дотоод сүлжээтэй компьютерийн “ISM” програм 2018.11.28-ны өдөр гацсан тул 10.204.32.21 IP хаягтай серверийг 10.204.32.22 IP хаягаар сольж “ISM” програмыг хэвийн ажиллагаанд оруулсан.

- “Чингис Хаан” олон улсын нисэх буудлын тус газрын харьяа ирэгчийн өрөөнд байрлах паспортын хуурмаглал шалгадаг ИОМ-ын компьютер ажиллахгүй байсныг 2018.11.30-ны өдөр засч хэвийн ажиллагаанд оруулсан.

- 2018.12.10-ны зорчигчийн мэдээлэл шалгадаг “APIS” програм ажиллахгүй байсныг шалгахад “Чингис хаан” ОУНБуудал 2-р давхрын тогоо бүрэн салгаснаас болж тус програмын сүлжээ тасалдсан, мөн интернет сүлжээ тасалдсан байсныг илрүүлж нисэх буудлын холбоо мэдээллийн албаны хариуцсан ажилтанд мэдэгдэн мэдээлэл авч APIS програм болон интернет сүлжээг хэвийн ажиллагаанд оруулсан.

- 2018.12.10-ны өдөр “ISM” програм удаашралтай гацаж байсны улмаас Хилийн 0218-р ангийн сүлжээний инженерүүдтэй хамтран ажиллаж өглөө 08:00-09:30 цагт мөн өдөр 15:00-17:00 цагийн хооронд “ISM” програмд авто зам, төмөр зам

бүгд зэрэг хандалт хийдэг. Энэ хугацаанд хэрэглэгчийн тоо нэмэгдэхэд серверээс мэдээлэл татах хурд удааширч, гацаж байгаа шалтгааныг олж тогтоолоо.

- Принтерийн тохиргоо алдагдсан 3 дуудлага хүлээн авч тухай бүрт хэвийн ажиллагаанд оруулсан.
- “Асег” маркийн нөүтбүүкийг форматлан, ашиглагдах програмуудыг суулган хэвийн ажиллагаанд оруулсан.

#### Гурав. Бусад

Гадаадын иргэн, харьяатын газрын ажилтан, албан хаагчдаас авах сэтгэл ханамжийн санал асуулгыг тус газрын албан хаагчдаар бөглүүлэн 2018 оны 12 дугаар сарын 04–ний өдөр Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлсэн.

Төвөөс 2018.12.03-04-ний өдрүүдэд захиргааны албан хаагчдын цугларалт зохион байгуулсантай холбогдуулан сургалтад хамрагдаж буй төв, орон нутаг дахь газрын албан хаагчдад 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдөр тус газрын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаатай танилцуулав.

Тус газрын Ёс зүйн хороо нь үйлчлүүлэгчдээс албан хаагчид иргэдтэй хэрхэн харьцдаг, түргэн шуурхай чирэгдэл учруулахгүй үйлчилж буй талаар болон ёс зүйн холбогдолтой асуудлаар судалгаа авах ажлыг 2018.11.20-26-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд уг судалгааг нэгтгэн газрын даргад мөн сарын 27-ны өдөр илтгэх хуудсаар танилцуулсан. Судалгаанд нийт 8 орны 30 гаруй гадаадын иргэн хамрагдсан бөгөөд албан хаагчдын харилцааны ёс зүйн талаар санал, хүсэлт ирээгүй ба үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж байгаад сэтгэл ханамж дүүрэн байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.